



Independent
Project
Accountability
Mechanism

Үнэлгээний тайлан

Улаанбаатар-Дарханы зам

ЕСБХБ Төслийн дугаар 50766

Кейс дугаар 2022/01

2022 оны 9-р сар

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХБХМ) нь Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ны хариуцлагын механизм юм. ТХБХМ нь банкнаас санхүүжүүлсэн төслөөс хохирол учруулсан, учирч болзошгүй гэж үзэж буй хувь хүн, байгууллагаас гаргасан асуудлыг хараат бусаар хянаж үнэлдэг. Энэхүү механизмын зорилго нь төсөлд оролцогч талуудын дунд нийгэм, байгаль орчин болон ил тод байдлын асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; банк нь байгаль орчин ба нийгмийн бодлого болон мэдээллийн хүртээмжийн бодлогынхоо төсөлд хамааралтай заалтуудыг мөрдөж ажилласан эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд эдгээр бодлогыг зөрчсөн аливаа зөрчлийг арилгахын зэрэгцээ цаашид зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилготой юм.

ТХБХМ-ын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл бидэнтэй холбогдож эсвэл www.ECBXB.com/project-finance/lpam.html цахим хуудаст зочилно уу.

Холбоо барих Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХБХМ) Европын сэргээн босголт хөгжлийн банк One Exchange Square London EC2A 2JN Утас: +44 (0)20 7338 6000 И-мэйл: lpam@ebrd.com	ТХБХМ-д хэрхэн гомдол гаргах вэ? ЕСБХБ төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн талаар санаа зовниж буй асуудлуудыг цахим шуудангаар, утсаар болон бичгээр эсвэл цахим хэлбэрээр дараах хаягт илгээж болно. https://www.ECBXB.com/project-finance/lpam.html
---	---

Агуулга

Гүйцэтгэх хураангуй	5
1. Ерөнхий мэдээлэл.....	6
1.1. Хүсэлт.....	6
1.2. Төсөл ба түүний өнөөгийн байдал	6
1.3. Кейсийн өнөөг хүртэлх шийдвэрлэлт.....	7
2. Үнэлгээ үе шат.....	7
3. Сайтаар дээр очиж ажилласан байдал.....	8
4. Талуудын байр суурийн хураангуй	10
4.1 Хүсэлт гаргагч.....	10
4.2. Харилцагч.....	12
4.3. ЕСБХБ-ны удирдлага.....	13
5. Үнэлгээний шийдвэр	14
6. Дүгнэлт ба дараагийн алхмууд.....	15

Өөрөөр нарийвчлан заагаагүй бол энэ тайланд том үсгээр бичсэн нэр томьёо нь 2019 оны Төслийн хариуцлагын бодлогод заасан нэр томьёог илтгэнэ.

ТОВЧИЛСОН ҮГС

Товчлол	Бүрэн нэр томьёо
АХБ	Азийн Хөгжлийн Банк
Захирлуудын зөвлөл	Банкны Захирлуудын зөвлөл
Кейс	Төслийн гомдлын механизмаас хүсэлтийг харгалзан үзэх ба 2020 оны 7-р сараас хойш Төслийн хариуцлагын бодлогын дагуу бүртгэсний дараах хүсэлт
Кейс бүртгэл	Төслийн хариуцлагын бодлогын III хэсгийн 3.1-д заасны дагуу ТХБХМ-ын цахим хуудаснаас харж болох кейст үүсгэсэн бүртгэл.
ЕСБХБ (эсвэл Банк)	Европын сэргээн босголт хөгжлийн банк
БОНБ	Төсөл батлах үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан ЕСБХБ-ны Байгаль орчин ба нийгмийн бодлого
ТХБХМ	2019 оны Төслийн хариуцлагын бодлогын дагуу байгуулсан ЕСБХБ-ны гомдлын хараат бус механизм
ТХБХМ-ын дарга	Төслийн хариуцлагын бодлогын хүрээнд ТХБХМ-ын үйл ажиллагааг явуулах, Төслийн хариуцлагын бодлогын хэрэгжилтийг хангах, мөн тус бодлогын дагуу ТХБХМ-ын шийдвэр гаргах ажлыг хариуцсан ТХБХМ-ын дарга.
км	километр
ТХБ	2019 оны Төслийн хариуцлагын бодлого
Талууд	Кейст ашиг сонирхол нь шууд холбогдож буй хувь хүн, этгээд ба байгууллагууд. Талууд (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй): Хүсэлт гаргагчид; хэрэв байгаа бол тэдгээрийн төлөөлөгчид; банкны холбогдох хэлтэс, баг, нэгж; харилцагч; болон төслийн бусад санхүүжүүлэгчид эсвэл төслийг хэрэгжүүлэх үүрэгтэй бусад этгээд
Асуудал шийдвэрлэх ажиллагаа	Хүсэлттэй хамааралтай байгаль орчин, нийгэм болон мэдээлэл нийтэд ил тод болгохтой холбоотой асуудлыг шийдвэрлэхийн тулд хүсэлт гаргагч болон харилцагч хоёрын сайн дурын яриа хэлэлцээг дэмжих чиг үүрэг.
ТХББ	Төслийн хураангуй баримт бичиг
Ерөнхийлөгч	ЕСБХБ-ны ерөнхийлөгч
ТВ	Телевиз

Гүйцэтгэх хураангуй

Хүсэлт

[Төслийн хариуцлагын хараат бүс механизм](#) (ТХБХМ)-ын Монгол улсын Төв аймгийн нутаг байрлах, Улаанбаатараас Дархан хот явах замд 108км-т орших Дуган хад амралтын газрын эзэн Лханаажавын Бүрэнтөгсөөс 2022 оны 3-р сарын 31-ний өдөр [хүсэлт](#) хүлээн авсан. Тэрээр Дарханы зам нь амралтын газарт хүрэх цорын ганц зам бөгөөд зам өргөтгөлийн ажлын улмаас 2019 оны 8-р сараас хойш хаагдсан тул ЕСБХБ-ны [Улаанбаатар-Дарханы зам \(50766\)](#) төслөөс түүний бизнест сөрөг нөлөө үзүүлж буй гэж үзсэн. Энэ байдлаас үүдэн түүний зочид буудлын захиалга огцом буурч, орлогоо алдаж, улмаар өр нь нэмэгджээ. Үүнтэй төстэй гомдлыг Азийн Хөгжлийн Банкны хариуцлагын механизмд мөн гаргасан байна. Хүсэлт гаргагч нь ТХБХМ-тай харилцахдаа асуудлыг шийдвэрлэх ба комплайнсын хяналтын ажиллагааг сонирхож байгаагаа илэрхийлсэн.

Төсөл¹

[Улаанбаатар-Дарханы зам \(50766\)](#) төслийн хүрээнд Монгол улсын авто замын сүлжээний чухал судас, Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын нэг хэсэг болох, Монгол Улсын хойд хэсэгт байрлах Улаанбаатараас тус улсын хоёр дахь том хот болох Дархан хот хүртэлх 202 км авто замыг өргөтгөх ажлыг хийх юм. Төслийн хураангуй баримт бичигт зааснаар ЕСБХБ-ны төсөл нь авто замыг дөрвөн эгнээ болгон өргөтгөн сайжруулах ажил бүхий II үе шатыг хамарч буй юм. Нэгдүгээр үе шат нь Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа бөгөөд одоо байгаа хоёр урсгалтай замыг сайжруулан засварлах ажлыг хамарч буй юм. Төслийг Монгол Улсын Зам тээвэр, хөгжлийн яам (харилцагч) хэрэгжүүлж байна. Төсөл нь ЕСБХБ-ны Захирлуудын зөвлөлөөс 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан 137 сая ам.доллар хүртэлх анхны зээл, мөн төслийн I, II үе шатыг бүтцийн хувьд уялдуулах шаардлагаас үүдэлтэй нэмэлт зардлыг санхүүжүүлэх зорилгоор тус зөвлөлөөс 2022 оны 2-р сарын 23-ны өдөр батлагдсан 20 сая ам.доллар хүртэлх хоёр дахь зээлээс тус тус бүрдэж буй юм. Төслийн зорилго нь дотоодын болон олон улсын хөдөлгөөний эрэлт хэрэгцээг хангахуйц хэмжээнд авто замын хүчин чадлыг нэмэгдүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг сайжруулахад оршино. Зээлийн статус батлагдсан хэмээх ангилалд байна.

ТХБХМ-ын үйл явц

Хүсэлтийг ТХБХМ 2022 оны 5-р сарын 17-ны өдөр [кейсийн дугаар 2022/01](#) олгон бүртгэж, [2019 оны Төслийн хариуцлагын бодлого \(ТХБ\)](#)-ын дагуу үнэлгээний үе шатыг эхлүүлж, 2022 оны 8-р сар хүртэл үнэлгээг явуулсан. ТХБХМ нь хүсэлт болон талуудаас ирүүлсэн нэмэлт мэдээлэлд нарийвчилсан дүн шинжилгээ хийж, төслийг хариуцсан банкны баг, харилцагч болон хүсэлт гаргагчийн төлөөлөлтэй онлайн уулзалт хийж, 2022 оны 7-р сарын 25-31-ний өдрүүдэд Монгол Улсад хүсэлт гаргагч, харилцагчтай газар дээр нь уулзаж, хүсэлтэй холбоотой төслийн бүсэд очиж танилцсан.

Дүгнэлт ба дараагийн алхмууд

Үнэлгээний үе шатанд хийсэн үйл ажиллагаа дээр үндэслэн ТХБХМ нь кейсийг комплайнсын чиг үүрэгт шилжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд холбогдох баг нь кейсийг ТХБ-д заасан шалгуурын дагуу комплайнсын хяналтад хамрагдах боломжтой эсэхийг тогтоохоор үнэлнэ. 2019 оны ТХБ-ын 2.3 (с)-д заасны дагуу үнэлгээний тайланг Захирлуудын зөвлөл болон Ерөнхийлөгчид мэдээлэл болгон хүргэх бөгөөд [кейс 2022/01](#) дугаартай цахим кейс файлд англи, монгол хэлээр нийтэлж, мөн холбогдох бүх талуудад ил болгосон тухай мэдэгдэнэ.

¹Төслийн хураангуй баримт бичгийг дараах холбоосоос авах боломжтой: <https://www.ebrd.com/work-with-us/projects/psd/50766.html>

1. Ерөнхий мэдээлэл

1.1. Хүсэлт²

2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Монгол улсын Төв аймгийн Улаанбаатар-Дархан хотын замын 108 км-т байрлах Дуган хад амралтын газрын эзэн хатагтай Лханаажавын Бүрэнтөгс (хүсэлт гаргагч) ТХБХМ-д хүсэлт гаргасан. Тэрээр Дарханы зам нь амралтын газарт хүрэх цорын ганц зам бөгөөд зам өргөтгөлийн ажлын улмаас 2019 оны 8-р сараас хойш хаагдсан тул ЕСБХБ-ны [Улаанбаатар-Дарханы зам \(50766\)](#) төслөөс түүний бизнест сөрөг нөлөө үзүүлж буй гэж үзсэн. Энэ байдлаас үүдэн түүний зочид буудлын захиалга огцом буурч, орлогоо алдаж, улмаар өр нь нэмэгджээ.

Цаашилбал, хүсэлт гаргагч нь замын ажил маш удаашралтай явагдаж байгаа бөгөөд ажлын явц, дуусах хугацааны талаар ямар нэг мэдээлэл өгөөгүй хэмээсэн. Хүсэлтэд дурдсанаар хэрэв ажил илүү удааширч, зам хаагдсан хэвээр байвал амралтын газрын үйл ажиллагаа бүрэн зогсоно гэжээ.

Хүсэлт гаргагч нь орон нутгийн бусад аж ахуйн нэгж, айл өрхүүд, тэдгээрийн дотор 30 жуулчны бааз, зургаан малын ферм, зургаан зоогийн газар, нэг амьтны хүрээлэн, мөн 100 гаруй газар тариалангийн компани, зам дагуу байрлах олон мянган өрхүүд тус замын ажлын сөрөг нөлөөлд өртсөн байна гэж мэдэгджээ. Хүсэлт гаргагч нь Зам, тээврийн хөгжлийн яам болон ЕСБХБ-нд хандсан боловч хариу өгөөгүй гэж тайлбарласан.

Хүсэлт гаргагч нь үүнтэй төстэй гомдлыг Азийн Хөгжлийн Банкны хариуцлагын механизмд давхар илгээсэн байна. Хүсэлт гаргагч нь ТХБХМ-тай харилцахдаа асуудлыг шийдвэрлэх ба комплайнсын хяналтын ажиллагааг сонирхож байгаагаа илэрхийлсэн.

1.2. Төсөл ба түүний өнөөгийн байдал³

[Улаанбаатар-Дарханы зам \(50766\)](#) төслийн хүрээнд Монгол улсын авто замын сүлжээний чухал судас, Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын нэг хэсэг болох, Монгол Улсын хойд хэсэгт байрлах Улаанбаатараас тус улсын хоёр дахь том хот болох Дархан хот хүртэлх 202 км авто замыг өргөтгөх ажлыг хийх юм. Одоогийн зам нарийхан, нүхтэй, шаардлагатай тээврийн хөдөлгөөнийг авах боломжгүй байна. Төслийн зорилго нь дотоодын болон олон улсын хөдөлгөөний эрэлт хэрэгцээг хангахуйц хэмжээнд авто замын хүчин чадлыг нэмэгдүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг сайжруулахад оршино. Зээлийн статус батлагдсан хэмээх ангилалд байна.

Төслийн хураангуй баримт бичиг (ТХББ)-т зааснаар ЕСБХБ-ны төсөл нь авто замыг дөрвөн эгнээ болгон өргөтгөн сайжруулах ажил бүхий II үе шатыг хамарч буй юм. Нэгдүгээр үе шат нь Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа бөгөөд одоо байгаа хоёр урсгалтай замыг сайжруулан засварлах ажлыг хамарч буй юм. Төслийг Монгол Улсын Зам тээвэр, хөгжлийн яам хэрэгжүүлж байна.

[Улаанбаатар-Дарханы зам \(50766\)](#) төсөл нь ЕСБХБ-ны Захирлуудын зөвлөлөөс 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан 137 сая ам.доллар хүртэлх анхны зээл, мөн төслийн I, II үе шатыг бүтцийн хувьд уялдуулах шаардлагаас үүдэлтэй нэмэлт зардлыг санхүүжүүлэх зорилгоор тус зөвлөлөөс 2022 оны 2-р сарын 23-ны өдөр батлагдсан 20 сая ам.доллар хүртэлх хоёр дахь зээлээс тус тус бүрдэж буй юм.

²Хүсэлтийг дараах хаягаар авах боломжтой: [Complaint+Ulaanbaatar+Darkhan+road+project+revised \(1\).pdf](#)

³ЕСБХБ-ны Төслийн хураангуй баримт бичгийг дараах хаягаар авах боломжтой: <https://www.ebrd.com/work-with-us/projects/psd/50766.html>

2014 оны Байгаль орчин, нийгмийн бодлогын дагуу байгаль орчин, нийгмийн нөлөөллийн иж бүрэн үнэлгээ хийх, үүнд олон нийтийн зөвлөгөөн хийж, Захирлуудын зөвлөлөөр батлуулахаас 120 хоногийн өмнө ЕСБХБ-наас нийтэд ил болгох шаардлагатай буюу А ангилалд тус төсөл хуваарилагдсан байна.

Төслийн баримт бичигт зааснаар төслийн үйл ажиллагаа нь тодорхой хэмжээнд эдийн засгийн дайжилт үүсгэж, барилга байгууламж буулгахад хүргэх боловч хүмүүсийн орон байр, үл хөдлөх хөрөнгөд нөлөөлөхгүй гэсэн байна. Төслийг ЕСБХБ-ын гүйцэтгэлийн шаардлагад нийцсэн бүтэцтэй болгох зорилгоор байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний нийтэд ил болгосон мэдээллийн багцад тодорхойлсон газар болон амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг зохицуулах газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн хүрээ гэх баримт бичгийг боловсруулсан байна.

1.3. Кейсийн өнөөг хүртэлх шийдвэрлэлт

Хүсэлт нь ТХБ-ын 2.2 (b) хэсэгт заасан бүртгэлийн шалгуурыг хангасан, мөн тус бодлогын 2.2 (c) хэсэгт заасан онцгой тохиолдлын аль нь ч энэ шатанд хамаарахгүй гэж үзсэн тул түүнийг 2022 оны 5-р сарын 17-ны өдөр бүртгэж авсан. Хүсэлтийг бүртгэсэн нь дараах шалгуурыг хангасан болохыг тогтоож буй захиргааны шинжтэй алхам юм⁴. Үүнд:

- шаардлагатай бүх мэдээллийг өгсөн;
- Байгаль орчин, нийгмийн бодлоготой холбогдуулан тус банкны хүлээх тодорхой үүргүүд болон/эсвэл мэдээллийн хүртээмжийн бодлогын төсөлд хамааралтай тодорхой заалтуудтай холбоотой асуудлыг хөндсөн; мөн
- банкнаас баталсан төсөлтэй холбоотой хүсэлт бөгөөд төсөл дэх банкны санхүүгийн оролцоо байхаа болсон өдрөөс хойш 24 сарын дотор тус хүсэлтийг ирүүлсэн тус тус болно.

2. Үнэлгээ үе шат

Хүсэлтийг бүртгэсний дараа хүсэлтийг 2019 оны ТХБ-ын 2.3 дах догол мөрөнд заасны дагуу дараах зорилгоор нэн даруй үнэлгээний шатанд шилжүүлсэн. Үүнд:

- хүсэлтэд дурдсан асуудлын талаар тодорхой ойлголттой болох;
- асуудлыг шийдвэрлэх болон комплайнсын чиг үүрэг, тэдгээрийн хамрах хүрээ, үр дүнг талуудтай хэлэлцэх;
- эдгээр чиг үүрэг тус бүрд талуудын оролцох хүсэл эрмэлзлийг үнэлэх;
- гомдлыг шийдвэрлэх бусад хүчин чармайлтаас үүссэн аливаа шинэ нөхцөл байдлыг авч үзэх; мөн
- гурван хувилбар бүхий үр дүн дээр эцсийн шийдвэр гаргах, үүнд:
- хүсэлт гаргагч болон харилцагчийн тохиролцсоны үндсэн дээр асуудал шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлж кейсийг үргэлжлүүлэх; эсвэл
- асуудлыг шийдвэрлэх ажиллагаа явуулах талаар тохиролцоонд хүрээгүй бөгөөд хүсэлт гаргагчийн шууд хүсэлтэд үндэслэн кейсийг комплайнсын үнэлгээнд шилжүүлэх; эсвэл
- кейсийг хаах тус тус болно.

Үнэлгээний үе шат нь хүсэлтийг бүртгэсэн өдрөөс хойш ажлын 40 хоногийн стандарт хугацаанд багтаан явагдах бөгөөд ТХБ-ын дагуу илүү боловсруулалт хийх эсвэл орчуулга хийх шаардлагатай бол сунгаж болно. Үнэлгээг 2022 оны 5-р сард эхлүүлж, 2022 оны 8-р сард эцэслэсэн болно.

⁴Хүсэлтийг бүртгэх нь түүнийг нийт агуулга, үнэн зөв эсэх алдаагүй эсэх талаар дүгнэлт гаргасан гэсэн үг биш. Мөн нөгөө л дэх банкны оролцоогтүдгэлзүүлэх нөлөө үзүүлэхгүй.

ТХБ-д заасан аргачлалын дагуу (ТХБ-ын 2.3-р заалтыг харна уу) үнэлгээний үе шатанд ТХБХМ-ын баг дараах ажлуудыг хийсэн. Үүнд:

- Төслийн холбогдох баримт бичгүүдийг хянан үзсэн;
- Төслийг хариуцсан банкны баг, харилцагч болон хүсэлт гаргагчийн төлөөлөгчидтэй онлайн уулзалт хийсэн;
- ТХБХМ-ын баг 2022 оны 7-р сарын 25-аас 31-ний хооронд Монгол Улсад газар дээр нь очиж танилцаж, хүсэлт гаргагч, харилцагчтай уулзаж, хүсэлттэй холбоотой төслийн сайт дээр ажилласан.

3. Сайтаар дээр очиж ажилласан байдал

ТХБХМ-ын баг нь Зам, тээврийн хөгжлийн яамны албан тушаалтнууд болон хүсэлт гаргагчтай биечлэн уулзаж, төслийн талаар илүү сайн ойлголттой болох зорилгоор төсөл хэрэгжиж замын дагуу явах, төслийн хүсэлтэд дурдсан асуудлуудтай холбогдож буй байдлыг харах үүднээс 7-р сарын 25-ны долоо хоногт Монголд ажилласан.

Багийн ажлын эхний өдөр төсөл хариуцсан төрийн албан хаагч нартай уулзсан. Гэвч тухайн өдрийн борооноос үүдэн тус замын саяхан ашиглалтад орсон хэсэг үерт автсан.

Улаанбаатар хотоос автомашин (жийп машин)-аар 7-р сарын 27-ны лхагва гаригт гарах байсан ч өмнөх өдөр орсон усархаг борооны улмаас нийслэл орчмын замын зарим хэсэг үерт автаж, хаагдахад хүрсэн.

Монгол Улсын Төв аймгийн нутагт Улаанбаатар-Дархан хотын авто замын 108 км-т байрлах тус амралтын газарт 7-р сарын 26-ны пүрэв гаригт очсон. Улаанбаатар хотоос амралтын газар хүртэл гурван цаг зарцуулсан.

Эхний 37.26 километрт (1-р хэсэг) төслийн I, II үе шатын шинэ авто зам баригдаж дууссан байсан бөгөөд зөвхөн жижиг хэсэг үерийн улмаас хаагдсан байна.

Харин дараагийн 45.5 километрт (2-р хэсэг) авто зам байхгүй, хажуугийн шороон замаар явах шаардлагатай болсон.

Шороон замын нөхцөл байдал нэлээд муу, тэмдэг тэмдэглэгээ байхгүй байсныг ТХБХМ-ын баг онцолж байна. Тээврийн хэрэгсэл мал бэлчсэн бэлчээр дундуурх түр замаар явж байсан.



Хучилт тавиагүй боловч хөдөлгөөнийг хаагаагүй гол замын хэсэг
Эх сурвалж: ТХБХМ



Түр замууд замууд
Эх сурвалж: ТХБХМ



Түр замууд
Эх сурвалж: ТХБХМ

Тус амралтын газар төв замаас 9 км зайд байрлах бөгөөд тус туслах зам нь замын хөдөлгөөн явахад хүндрэлтэй байсан. Тус амралтын газар сүүлийн 50 жил үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2000 онд хувьчлагдсан. Хүсэлт гаргагч нь 2018-2019 онд барилга байгууламжаа шинэчилж, өргөтгөсөн байна.



Дуган Хад амралтын газрын барилга байгууламж
Эх сурвалж: ТХБХМ



Дуган Хад амралтын газрын барилга байгууламж
Эх сурвалж: ТХБХМ

4. Талуудын байр суурийн хураангуй

Энэ хэсэгт цахим болон биечлэн хийсэн уулзалтын үеэрх ТХБХМ-ын олж авсан хүсэлт гаргагч, харилцагч болон банкны удирдлагын байр суурийг багтаасан болно. ТХБХМ нь тайланг эцэслэн гаргахаасаа өмнө үнэн зөв байдлыг баталгаажуулахын тулд талуудтай холбогдох хэсгүүдийг хуваалцсан.

4.1 Хүсэлт гаргагч

Бүртгэл болон үнэлгээний үе шатанд буюу 2022 оны 3-р сараас 8-р сар хүртэл ТХБХМ-ын баг төслийн нөлөөллийн талаар хүсэлт гаргагчтай цахим шуудан болон цахим платформоор тогтмол харилцаж ажилласан. Хүсэлт гаргагч нь харилцагч болон банктai харилцах гэж оролдсон боловч ТХБХМ-д хүсэлт гаргахаас өмнө тавьсан асуудлын талаар ямар ч ямар ч хариу аваагүй гэдгээ хүсэлт гаргагч эдгээр уулзалтын үеэр хэлж айсн. Ялангуяа 2021 онд тэрээр АХБ, ЕСБХБ руу залгасан боловч хэн нь ч утсаа аваагүй байна.

Хүсэлт гаргагч нь гэр бүлийнхээ хамт сүүлийн 20 жилийн хугацаанд 400 хүртэлх зочин хүлээн авах хүчин чадалтай Монголын хамгийн том амралтын газрыг удирдан ажиллуулж ирсэн гэж тайлбарласан. Тэрээр амралтын газар нь ихэвчлэн компанийн харилцагч (жишээ нь, баг хамт олны амралт, хурал)-дад үйлчилдэг хэмээсэн. Нэмж дурдахад амралтын газар нь зуны баяр наадам, спортын уралдаан тэмцээнд оролцохоор ирсэн бусад төрлийн зочид, явган аялал, хаданд авирахыг сонирхож буй зочдыг 6-9-р сард хүлээн авдаг байна.

Тэрээр 2019 оны 8-р сард Улаанбаатар-Дархан чиглэлийн замыг хааснаас үүдэн амралтын газрын үйл ажиллагаа нь бараг нэг өдрийн дотор зогссон тухайгаа ярьсан. Түүний хэлснээр ойр орчмын иргэдэд зам хаах тухай мэдэгдээгүй, мөн хаасан замын хажуугаар түр зам байгаа ч замын нөхцөл байдал муу байна.

Зам хаагдахаас өмнө Улаанбаатар хотоос тус амралтын газар машин эсхүл автобусаар зорчиж хүрэхэд нэг цаг зарцуулдаг байсан бол одоо гурван цаг зарцуулдаг гэж тэр хэллээ. Үүнээс болж түүний хуучин харилцагчид нь Монголын зүүн хэсэгт байрлах зам сайтай амралтын газруудыг сонгоход хүргэсэн гэж хүсэлт гаргагч үзэж байна.

Тэрээр КОВИД-19 цар тахал Монголын аялал жуулчлалын салбарт нөлөөлсөн гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа ч түүнээс өмнө бизнес нь унаж эхэлсэн гэж мэдэгдсэн. Түүгээр ч барахгүй тэрээр КОВИД-19 цар тахлын нөхцөл байдал саяхан сайжирч, ямар ч хөл хорио байхгүй болсон ч түүний бизнес бараг сайжирсангүй гэж тайлбарлав. Борлуулалт буурсан нь тухайн хугацаанд Монгол Улсын татварын албанд гаргаж, ТХБХМ-д илгээсэн татварын тайлангаар нотлох боломжтой гэв.⁵ Амралтын өдрүүдэд одоо 40 орчим зочин хүлээж авдаг бөгөөд өмнөх өдөр нь бороо орж, төв замын нэг хэсэг урссан улмаас амралтын өдрүүдийн захиалга цуцлагдсан гэж тэрээр хэллээ.

Зам хаагдахын өмнөхөн амралтын газрынхаа хүчин чадлыг нэмэгдүүлэхийн тулд банкнаас зээл авсан тухайгаа тэрээр нэмж тодруулаа. Бизнес нь унасан тул зээлээ төлж чадахгүй, дансыг нь битүүмжилсэн, Монголын төрийн байгууллагаас гадаадад зорчих эрхийг нь хязгаарласан байна.

Амралтын газар 20 (өвлийн улиралд) - 35 (зуны улиралд) ажилтантай байсан. Тэдний дийлэнхийг нь ажлаас нь гаргаж, цалинг нь төлөхийн тулд байраа зарж, амралтын газраа зарах гэж оролдсон боловч зам муутайгаас болж олигтой санал ирээгүй байна.

Хүсэлт гаргагч нь гурван өрхийн амьдралыг авч яваа өрхийн тэргүүн бөгөөд хэрэв зам удаан хаагдахыг мэдсэн бол амралтын газраа өргөтгөхгүй байсан хэмээн ТХБХМ-тай хийсэн уулзалтын үеэр ярих.

Түүнчлэн, уг зам нь замын хөдөлгөөний аюулгүй байдалд ноцтой эрсдэл учруулж буй бөгөөд тоосжилт, үзэгдэх орчин муудсаны улмаас 40 орчим хүний амь нас хохирсон зэрэг зам тээврийн осол ихээр гарч байгааг хүсэлт гаргагч мэдэгдэв. Төслийн нөлөөллийн талаарх мэдээллийг түгээх зорилгоор байгуулагдсан Facebook группт ойр орчмын 1000 орчим хүн нэгдэж орсон бөгөөд түүний хөршүүдийн ихэнх нь гомдол гаргах эрхээ мэдэхгүй учраас гомдол гаргаагүй байгаа гэж тэрээр мөн хэлсэн. Түүний амралтын газрын яг урд байрлах бизнес эрхлэгч амралтын газраа зүгээр л хаахаар шийдэж, эд хөрөнгөө харж байгаарай гэж түүнд захисан байна.

Хүсэлт гаргагч нь өөр хандах газар үлдээгүй учраас эрхээ сэргээхээр ТХБХМ-д хандаж байгаагаа дахин тодотгов. Тэд зам нээгдэхийг гурван жил гаруй тэвчээртэй хүлээсэн ч нээгдээгүй байна. Хүсэлт гаргасны дараа яамны төрийн албан хаагчид түүнтэй уулзаж, төслийн баримт бичгийг хуваалцаж, орон нутгийн гомдлыг барагдуулах механизм хариуцсан ажилтантай танилцуулсан болохыг тэрээр баталгаажуулав. Гэсэн хэдий ч тэд түүнд гомдол байгаа бол гүйцэтгэгч компанид хандах хэрэгтэй гэж хэлсэн гэдгийг тэрээр онцлов.

Саяхан тэрээр гомдлын барагдуулах механизм хариуцсан албан тушаалтанд хандаж, байгаль орчин, нийгмийн тайланг хүссэн боловч нийтэд нээлттэй биш болохыг олж мэдсэн байна.

Хүсэлт гаргагч нь өөрт учирсан гэж үзэж буй эдийн засгийн хохирлын нөхөн төлбөрийн талаар ярилцах зорилгоор ТХБХМ-ын тусламжтай асуудлыг шийдвэрлэх санаачилгад оролцох сонирхолтой байгаагаа

⁵Хүсэлт гаргагч нь 2018, 2019, 2020, 2021 оны татварын тайлангийн хуулбараа ТХБХМ-д ирүүлсэн.

илэрхийлэв. Асуудлыг шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй бол хүсэлт гаргагч кейсийг ТХБХМ-ын комплайнсын чиг үүргийн хүрээнд авч үзэх хүсэлтэй байгаагаа мөн илэрхийлсэн.

4.2. Харилцагч

ТХБХМ нь 2022 оны 6-р сарын 10-ны өдөр харилцагчтай цахимаар харилцаж, 2022 оны 7-р сарын 26 болон 27-ны өдрүүдэд Монгол Улсын Улаанбаатар хотод Зам, тээврийн хөгжлийн яамны дөрвөн албан тушаалтантай биечлэн уулзав.

Харилцагч биечлэн хийсэн уулзалтын үеэр Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын нэг хэсэг болох уг төсөл нь тус улсын хувьд чухал болохыг батлан хэллээ. Харилцагч нь төлөвлөсөн ажлынхаа 46 орчим хувийг гүйцэтгэсэн байгаа, мөн энэ зуны хугацаанд ахиц гаргах төлөвтэй байгаагаа ТХБХМ-д дуулгав. Замын барилгын ажлыг олон улсын тендерт шалгарсан янз бүрийн гүйцэтгэгч компаниудад тус бүр хариуцуулан таван багцад хуваасан гэж тэд тайлбарлав.

Тэд мөн төслийг хоёр үе шаттайгаар хуваасан гэж тайлбарлав. Эхнийх нь Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр, хоёр дахь нь ЕСБХБ-ны санхүүжилтээр явагдахаар төлөвлөсөн байна. Тэд уг замыг 2019 оны зун хааж, Улаанбаатараас амралтын газар байрлах хэсэг хүртэлх замыг хоёр хэсэгт хувааснаас 1-р багцын ажил дууссан болохыг баталгаажуулж хэлэв. Гэвч 2-р хэсэг нь хэд хэдэн удаа саатсан бөгөөд гүйцэтгэгч компани одоогийн байгаа замын дээд давхаргыг хуулж, ажлаа дуусгаагүй тул хөдөлгөөнийг түр тоос шороон замаар явуулж буй хэвээр байна.

Эхлээд сонгогдсон БНХАУ-ын гүйцэтгэгч компани хөл хорионы үеэр ажиллах хүчээ Хятадаас Монгол руу авчрах боломжгүй байснаар хугацаа авсан, дараа нь ажлын хуваариа бараг биелүүлж чадаагүй тул харилцагч гэрээгээ цуцалж, шинээр худалдан авах ажиллагааг эхлүүлэх шаардлагатай болсон. 2021 оны 9-р сард тэд 1-р үе шатны ажлыг (АХБ-ны санхүүжилттэй) хийж дуусгах боломжтой хэмээн найдаж буй шинэ компанийг тодорхойлсон бөгөөд ийнхүү ажлыг дуусгасан байх нь 2-р үе шатад (ЕСБХБ санхүүжилттэй) тавигдаж буй шаардлага юм.

Зам дагуух иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг тооцохдоо замаас 4м-ийн зайд байгаа талбайг хамруулсан гэх тайлбарыг өглөө. Түүнчлэн, Монгол бол чинээлэг орон биш учраас эдийн засгийн түр зуурын дайжилтад нөхөн төлбөр өгөх боломжгүй гэж мэдэгдэв.

Хүсэлтэд дурдсан асуудлын тухайд харилцагч нь тус амралтын газар нь төв замаас 8км зайд байрладаг тул төслийн нөлөөллийн бүсэд тооцогдохгүй, нөхөн төлбөр өгөх боломжгүй гэж тайлбарлав. Тэдний үзэж байгаагаар хүсэлт гаргагчийн мэдэгдсэн нөлөөлөл нь зөвхөн КОВИД-19 цар тахлын хөл хориотой холбоотой байна. Цаашилбал, хүсэлт гаргагчийн алдагдсан орлогыг нөхөх нь харилцагчийн үүрэг хариуцлага биш гэж тэд тайлбарлав. Мөн, тэд түр замаар явах боломж нь байнга байсаар ирсэн боловч нөхцөл муутай гэдгийг хүлээн зөвшөөрөв. Тэдний үзэж байгаагаар гол замаас салсны дараа амралтын газар руу явдаг туслах зам илүү муу бөгөөд энэ нь хүсэлт гаргагчийн нөхцөл байдалд нөлөөлсөн байж болзошгүй юм.

Замын өнөөгийн нөхцөл байдалд түр замаар зорчих нь өмнөхөөсөө гурав дахин их хугацаа шаардагдаж байгааг харилцагч хүлээн зөвшөөрсөн. Гэхдээ Улаанбаатар-Дарханы замаар өдөрт 100 орчим машин зорчиж байгаагийн дотор ОХУ-аас Хятад руу явж байгаа хүнд даацын машинууд ч байгаа гэж тэд хэлэв.

Мэдээллийг нийтэд ил болгох, оролцогч талуудын оролцоог хангах тал дээр тус яамнаас зам хаагдах талаар мэдээлэх үүднээс хэвлэл мэдээллийн хэрэгсэл (ТВ, интернет) ашиглаж ирсэн бөгөөд түр зам руу оруулах тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан талаар ТХБХМ-д хэлэв. Төслийн гомдол барагдуулах

механизмын асуудал дээр сумын⁶ орон нутгийн засаг захиргаа хариуцаж байгаа, 2022 оноос төсөл хэрэгжүүлэх нэгжид нийгмийн асуудал, гомдол хариуцсан хоёр хүнтэй болсон гэж тайлбарлав. Орон нутгийн хоёр ажилтныг ажилд авахын өмнө иргэд санал гомдлоо яам руу шууд илгээдэг байсан байна. Асуудлыг шийдвэрлэх санаачилгад оролцох тухайд, хүсэлт гаргагчийн тавьсан асуудал нь төсөлтэй холбоогүй тул ТХБХМ-ын үйл явцын хүрээнд шийдвэрлэх боломжгүй гэж харилцагч үзсэн.

4.3. ЕСБХБ-ны удирдлага

ТХБХМ нь 2022 оны 6-р сарын 10-ны өдөр ЕСБХБ-ны удирдлагуудтай цахим уулзалт хийж, түүнээс хойш хэд хэдэн удаа бичгээр мэдээлэл солилцов. Банкны удирдлагууд төслийн хэрэгжилтийн талаар шинэчилсэн мэдээлэл өгч, ТХБХМ-ын анхаарал тавьж буй асуудлаар өөрсдийн байр сууриа илэрхийлсэн. Мөн холбогдох багаас ТХБХМ-ын үнэлгээнд зориулж төсөлтэй холбоотой баримт бичгүүдийг хуваалцсан.

Уулзалтын үеэр банкны удирдлагууд ЕСБХБ болон АХБ хоёулаа Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын төслийг санхүүжүүлж байгаа болохоо тайлбарласан. АХБ нь одоо байгаа хоёр эгнээг сэргээн засварлах ажлыг хамарсан төслийн 1-р үе шатыг санхүүжүүлж буй бол ЕСБХБ нь Улаанбаатараас Дархан хүртэлх 202 км авто замд хоёр шинэ эгнээгээр нэмж өргөтгөх 2-р үе шатыг санхүүжүүлж буй юм. ЕСБХБ-ны төсөлд эргэлт, тойрог зогсоол, замын тохижилт (хаалт, гэрэлтүүлэг, явган хүний гарц гэх мэт) хийх, түүнчлэн найман төмөр зам дээгүүр гарам барих, гүүр, ус дамжуулах шугам хоолой барих, засварлах, төлбөр хураах цэгүүдийг шинэчлэх зэрэг ажил мөн багтсан байна.

ЕСБХБ-ны зээлийн гэрээг 2020 оны 1-р сард байгуулж, барилгын ажлыг 2021 оны 3-р сард эхэлсэн гэдгийг тэд ТХБХМ-д мэдээллээ. Төслийн өргөтгөлийн ажлын хүрээнд зам хаах шаардлага үүсгэхгүй, мөн АХБ-ны санхүүжилттэй 1-р үе шатын хүрээнд хийсэн зам засварын ажлаас үүдэн одоо байгаа зам хаагдсан гэж банкны удирдлагууд нэмж мэдэгдэв.

Геологийн онцлогоос шалтгаалж зэрэгцээ барилгын ажил явуулах хүндрэлтэй байх тул АХБ одоо байгаа хоёр эгнээг сэргээн засварлаж дууссаны дараа ЕСБХБ 2-р үе шатыг эхлүүлэхээр зээлдүүлэгчид болон харилцагч хоорондоо тохиролцсон гэж банкны удирдлагууд мэдэгдэв. ЕСБХБ-ны төсөл 2р үе шатыг хэрэгжүүлэх үед сайжруулсан засварласан одоогийн зам (1-р үе шатын зам)-ыг нэвтрэх зам болгох ашиглах төлөвлөгөөтэй байсан байна. Тэд хоёр зээлдүүлэгчийн хооронд үүрэг хариуцлагаа тодорхой хувааж авсан бөгөөд 1 болон 2-р үе шатын хүрээнд өөрсдийн гэсэн туслан гүйцэтгэгчид авсан хэмээн нэмж мэдэгдэв. АХБ түр зам болон 1-р үе шатын хэрэгжилтэд шаардлагатай холбогдох байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах ажлыг хариуцахаар зээлдэгчид тохиролцсон хэмээн банкны удирдлага нэмж тайлбарлав.

Барилгын ажил удааширсан, КОВИД-19 цар тахлын хөл хорио болон бусад хүчин зүйлийн улмаас АХБ-ны санхүүжилттэй барилгын ажил 2019 онд дуусгахаар төлөвлөж байсан ч ЕСБХБ-ны санхүүжилттэй барилгын ажил эхлэх үед тэдний барилгын ажил хойшилсон, үргэлжлэн явагдаж байсан болохыг банкны удирдлагууд тодотгов. АХБ-ны бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд арчилсан түр замуудын нөхцөл байдал төдийлөн сайн биш байгаа нь машинаар явахад хүндрэл учруулж байгаа, илүү сайн арчлах боломжтой байсныг банкны удирдлагууд хүлээн зөвшөөрсөн.

Төслийн үйл ажиллагаа нь зарим эдийн засгийн дайжилт, барилга байгууламжийн алдагдалд хүргэнэ гэх хүлээлттэй байсан бөгөөд нү ү лгэн шилжү ү лэх барилга байгууламжид нөхөн олговор олгох журмын талаар тохиролцохоор харилцагчийн зүгээс хөрөнгө өмчлөгч нартай харилцах ажлыг явуулсан боловч ү нэлгээний явцад төслийн нөлөөлөлд өртсөн иргэд амьдарч буй үл хөдлөх

⁶Сум нь Монгол Улсын аймаг доод шатна засаг захиргааны хоёр дахь шатны нэгж юм. Сум нь цаашлаад багуудад хуваагдана.

хөрөнгө тогтоогдоогүй гэдгийг банкны багийн зүгээс тодруулсан. Газар болон амьжиргааны нөлөөллийг зохицуулахад харилцагчид туслах зорилгоор ЕСБХБ-ны донорын санхүүжилтээр нүүдэллэн шилжүүлэх үйлдлийн мэргэжилтнүүдийн баг авч ажиллуулж, газар чөлөөлөх, нүүдэллэн шилжүүлэхтөлөөлөгөөр боловсруулсан гэж банкны удирдлага нэмж хэлэв. 2-р үе шатын газар чөлөөлөх, нүүдэллэн шилжүүлэх энэхүү төлөвлөгөөнд төслийн нөлөөлөлд өртсөн бүс доторх замын коридорын дагуух нөлөөлөлд өртсөн үйлдлэх хөрөнгө, барилга байгууламжийг тодорхойлсон. Мөн тус төлөвлөгөөнд хүсэлт гаргагчийн амралтын газрыг авч үзээгүй гэдгийг тэд тодруулав.

ЕСБХБ-ны төслөнхүү хүсэлт гаргагчийн тавьсан эдийн засгийн дайжилтын асуудалтай холбоогүй гэж банкны удирдлагууд үзсэн байна. Сөрөг нөлөөлөл нь КОВИД-19-ийн хөл хорио ба хязгаарлалт, 1-р үе шатын хүрээнд зам хаагдсаны үр дагавар байж болзошгүй гэж тэд үзэж байна. Үүнээс гадна, Дэлхийн Банкны дата, мэдээлээр Монгол Улсын аялал жуулчлалын салбар 2019-өөс 2020 он хүртэл 90 орчим хувиар буурсан гэж тэд нэмж дурдав. Түүнчлэн, Монголын аялал жуулчлал гадаад жуулчдаас ихээхэн хамааралтай байсан бөгөөд 2020 оны 2-р сараас эхлэн жуулчин авахгүй байх хоригтой байж байгаад 2022 оны 2-р сард саяхан дахин авч эхлэх боломжтой болгосон гэж мөн дурдав.

Эцэст нь, мэдээлэл хангалттай өгөөгүй гэх гомдлын хувьд ЕСБХБ болон АХБ аль аль нь төслийн талаар орон нутгийн иргэд мэдээлэлтэй болгохыг баталгаажуулж, 2017-2019 онд төслийн оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөний дагуу хэд хэдэн оролцоог хангах үйл ажиллагаа (ярилцлага, судалгаа, олон нийтийн хэлэлцүүлэг гэх мэт) явуулсан гэж банкны удирдлагууд тайлбарлав. Түүнчлэн, харилцагч болон гүйцэтгэгч нар өөрийн хариуцсан хэсгүүдэд зориулан төслийн гомдол барагдуулах механизмыг байгуулж, удирдан зохион байгуулсан хэмээн банкны удирдлага тайлбарлав.

5. Үнэлгээний шийдвэр

ТХБ-д заасанчлан ТХБХМ нь үнэлгээний үе шатанд хүсэлтийг тус бодлогын 2.2-т заасан бүртгэлийн шалгуурыг хангаж байгаа эсэхийг шалгасан. Хүсэлт нь бүртгэлийн шалгуурыг хангасан гэж ТХБХМ үзэж байна.

Энэ үе шатанд ТХБХМ нь хүсэлт гаргагч, банкны удирдлага, харилцагчийн хуваалцсан бичиг баримттай танилцаж, талуудтай биечлэн уулзаж, Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын холбогдох хэсэгт очиж танилцсан. Газар дээр нь очиж танилцах үеэр ТХБХМ нь уг замыг 2019 оны зунаас хаасан бөгөөд холбогдох нэг хэсэг нь 2022 оны зун хаалттай хэвээр байгаа болохыг олон төрлийн эх сурвалжаас баталгаажуулж авсан. Цаашилбал, ТХБХМ-ын баг нь Улаанбаатар хотоос амралтын газар руу зорчихдоо гурван цаг шаардаж буй, түр замуудын нөхцөл байдал хэт муу, мөн замын тэмдэг тэмдэглэгээ байхгүй байгааг нотолсон.

ТХБХМ мөн хэд хэдэн осол гарсан, мөн эдгээр ослоуд болон төслөөс үүдэлтэй бусад нөлөөллөөс болж оршин суугчид болон аялагчдаас гомдол ирсэн талаар янз бүрийн оролцогч талуудаас сонссон.

Банкны удирдлага, харилцагч болон хүсэлт гаргагчтай уулзсаны дараа харилцагч болон банкны удирдлагууд хүсэлт гаргагчийн тавьсан асуудал нь тэдний үүрэг хариуцлага биш гэсэн байр суурьтай болохыг олж мэдсэнээр ТХБХМ нь асуудлыг шийдвэрлэх санаачилга явуулах нь эерэг үр дүнд хүргэхгүй гэж үзлээ.

Асуудлыг шийдвэрлэх ажиллагаа нь сайн дурын үндсэн дээр явагддаг тул ТХБХМ энэхүү кейс дээр асуудал шийдвэрлэх ажиллагаа нь тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тохиромжгүй гэж шийдэв.

6. Дүгнэлт ба дараагийн алхмууд

Үнэлгээний үе шатанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд үндэслэн ТХБХМ нь кейсийг комплайнсын чиг үүрэгт шилжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд холбогдох баг нь ТХБ-д заасан шалгуурын дагуу комплайнсын хяналтад кейсийг хамруулах боломжтой эсэхийг тогтоохоор үнэлгээ хийнэ.

Энэхүү үнэлгээний тайлангийн төслийн холбогдох хэсгүүдэд талуудын байр суурийг үнэн зөвөөр тусгахын тулд тэдэнтэй хуваалцсан. Үүний дараа 2019 оны ТХБ-ын 2.3 (с)-д заасны дагуу үнэлгээний тайланг Захирлуудын зөвлөл болон ерөнхийлөгчид мэдээлэл болгон хүргэнэ. [Кейс 2022/01](#) дугаартай цахим кейс файлд үүнийг англи, монгол хэл дээр ил болсон тухай талуудад мэдэгдсэний дараа тус кейс нь комплайнс руу шилжинэ.